

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭН АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ ЗАР

Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журмын 4 дүгээр зүйлийн 4.2-т заасны дагуу төрийн өөр байгууллага, нэгж хооронд шилжин ажиллахыг хүссэн төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдыг дараах албан тушаалд холбогдох материалаа ирүүлэхийг урьж байна.

Тавигдах болзол, шаардлага:

- төрийн жинхэнэ албан тушаалд зохих ёсоор томилогдсон байх;
- зарлагдсан албан тушаалтай адил төрөл болон адил ангилалд ажилладаг байх;
- зарлагдсан албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан байх.

БҮРДҮҮЛЭХ бичиг баримт

1. Хүсэлт
2. Төрийн албан хаагчийн анкет
3. Иргэний үнэмлэхний хуулбар
4. Төрийн жинхэнэ албаны тангараг өргөсөн “Тангаргийн хуудас” хуулбар
5. Боловсролын түвшинг тодорхойлсон баримт бичиг /диплом/, хэрэв гадаад улсад их, дээд сургууль төгссөн бол боловсролын баримт бичгийн баталгаат орчуулгыг хавсаргах;
6. Мэргэшүүлэх сургалтад хамрагдаж төгссөн сертификат
7. Нийгмийн даатгалын дэвтэр болон шимтгэл төлсөн цахим лавлагаа
8. Албан тушаалд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал, шийдвэрийн хуулбар
9. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тухай тодорхойлолт /e-mongolia–аас татан авах/.
10. Сахилгын шийтгэлтэй эсэх тодорхойлолт
11. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээний хуудас
12. Цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэний хувьд цэргийн үүрэгтний үнэмлэх

Материал хүлээн авах:

- Хугацаа: 2026 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс 03 дугаар сарын 30-ны өдрийн 17:00 цаг хүртэл
- Материал хүлээн авах хаяг: badamsuren@mrt.gov.mn
- Холбоо барих утас: 51263179

**Зам, тээврийн яамны удирдах албан тушаалын
шилжүүлэн авах зарлал:**

№	Холбогдох мэдээлэл	Ангилал	Тавигдах шаардлага			
			Боловсрол	Мэргэжил	Мэргэшил	Туршлага
Нэг. Удирдах албан тушаал						
1.	Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга	Эрхэлсэн түшмэл-ТЗ-2	Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй	- санхүү /0412/; -эдийн засаг /0311/; - нягтлан бодох бүртгэл /0411/.	-Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж, төгссөн байх. -Мэргэшсэн нягтлан бодогч байх.	-Төрийн албанд 8-аас доошгүй жил, үүнээс ахлах түшмэлийн албан тушаалд 4-өөс доошгүй жил ажилласан байх; -Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хувьд төрийн албанд 4-өөс доошгүй жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил ажилласан байх. -Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журмыг хангасан байх.